

Таалал тогссон Их Удирдагч Ким Жонг Илийн чандарыг нийтэд болон гадаадын жуулчдад үзүүлнэ гэж байсан Хойд Солонгосын тал, онгорсон 21-ний одроос эхлэн амлалтандаа хүрч эхэллээ.

Хятадын " Young Pioneer Tours " хэмээх жуулчны компани Хойд Солонгос улсад гадаадын болон хятадын жуулчдыг аялуулдаг богоод тэднээр дамжуулан гадаадын жуулчид анх удаагаа эцэг , хvv нарын чандар байрлах Кымсv ууланд дурсгалын цогцолборт зочилжээ.

Яг л унтаж буй мэт шилэн хоргоны цаана харагдаж буй Их Удирдагч Ким Жонг Илийн чандарыг үзэхээр очсон жуулчдаас чандарын омно заавал бохийн мэндчилж хvндэтгэл үзүүлэх шаардлагыг тавих богоод хоргоны хажууд 4 буутай цэрэг хамгаалалтанд зогсож , чанга ярих хориотой тул чихэнд зvүлгэсэн микрофоноор англи хэл дээрх орчуулга сонсоно гэнэ. Уг цогцолборт орохоос омно жуулчдын гутлыг автомат цэвэрлэгчээр цэвэрлэн ,омссон хувцасных нь тоосыг авдаг богоод vвний дараа буу зэвсэг байгаа эсэхийг шалгаж 90 минутийн хугацаанд уг цогцолборыг үзүүлж дуусгадаг ажээ.

Хойд Солонгос улсыг vүсгэн байгуулагч Ким Ил Сений чандарыг таалал тогссонийх нь 1 жилийн дараа торийн ондор албан тушаалтнуудад, 2 жилийн дараа зовхон оорийн орны иргэддээ үзүүлж байсан бол энэ удаа тvвний хvвгийн чандарыг талийгч болсных нь 1 жилийн дараа гадаадын иргэдэд үзүүлж байгаа юм байна.